		Актанд бүхэлчилж 3,000,000.0 төгрөгөөр тусгав

Дүйцүүлэн хамгаалах ажлыг 2024 оны 09-р сарын 30-ний өдөр хүлээн авч 2 талаас акт үйлдэн баталгаажуулсан. Үйлдсэн актанд зарцуулсан зардлын хэмжээг 3.0 сая.төгрөг гэж тусгав.

2.4 Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөны биелэлт

Уурхайн түүх соёлын өвийг хамгаалах талаар жил бүр тодорхой хэмжээний ажил төлөвлөн гүйцэтгэж ирсэн.

- 2021 оны 9-р сарын 4-нд сумын Байгаль Орчны ажилтан болон Соёлын Төвийн бусад мэргэжилтэнгүүдтэй хамтран сумын нутаг дэвсгэрт байгаа соёлийн биет өвийн тодорхой хэсгийн судалгаа болон түүнийг сэргээн засварлах ажилд компаний зүгээс унаа болон жолоочоор хангаж, түүнтэй холбоотой зардлыг хариуцаж ажилласан.
- 2022 онд уурхай ажиллаагүй боловч “Их нартын байгалийн нөөц газар”-тай хамтын ажиллагааны хүрээнд “Их нартын судалгааны төв”-ийн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах үүднээс 6 тн нүүрс хандивлаж судалгааны ажлыг тасралтгүй явуулахад дэмжлэг үзүүлж, хамтарч ажилласан.
- 2024 онд Их Нартын Цогцолбор газраас нүүрс авах санал ирүүлээгүй байна. Ирүүлсэн нөхцөлд олгоход бэлэнг

Хүснэгт 13. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

№	Арга хэмжээ	Гүйцэтгэсэн ажил	Зардал мян.төг
1	Түүх, соёлын өв дурсгалуудын талаарх мэдээлэлд анхааралтай хандах, сэргээх ажилд оролцох	Тайлант онд түүх соёлын өвийг хамгаалах ажлын хүрээнд тус сумын бичигт багийн Их нартын байгалийн нөөц газрын “Цагаан Өвгөн” хадны зургыг хамгаалахад тухайн орчныг хашаажуулах, тэмдэгжүүлэх ажлыг хийсэн.	664.0
2	Нутгийн иргэдийн уламжлалт амьдралын хэв маяг, тахилга шүтлэгт хүндэтгэлтэй хандах, дэмжлэх үзүүлэх	Иргэдийн уламжлалт өв соёлын нэг хэсэг сумын 100-н жилийн баяр наадмын үйл ажиллагаанд зориулан хандив өргөв.	50,000.0
	Дүн		50,664.0



Зураг 41. Түүх соёлын биет өвийг судлах хамгаалах ажил /Их нартын нөөц газар-Цагаан өвгөний хадны зураг/



Зураг 42. Сумын нэрэмжит шагайн харвааны тэмцээн / 2024 оны 10-р сар /

2.5 Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Уурхайн үйл ажиллагааны явцад бүх ажилчдын сургалт, ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой зардал, өдөр тутмын уурхайн үйл ажиллагааг хэвийн явуулахад зайлшгүй мөрдөгдөх ХАБЭА-н зааварчилгаа гэх мэт ажлууд урьд жилүүдийнх шиг хийгдэж байна.

Мөн ажлын байрны ариутгал, хувь хүний гарын болон биеийн ариун цэвэрт байнгын анхаарал хандуулж байлаа. Ажилчдын дархлааг сэргээх амин дэм, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эм хэрэгсэлээр хангаж ажлууд шат дараатай хийгдлээ.

Үүний хажуугаар уурхайн өдөр тутмын ажлын байрны зааварчилгаа, сар улирлын сургалтын өөрийн нөөц бололцоонд тулгуурласан хийлээ.

Хүснэгт 14. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Гүйцэтгэсэн ажил	Зардал мян.төг
Байгалийн гамшигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр			
1	Цаг агаарын гэнэтийн үзэгдлээс уурхайн ажиллагаа доголдох, зогсох	Цаг агаарын аюулт үзэгдэл болох хүчтэй салхи, шороон болон цасан шуурганы улмаас уурхайн үйл ажиллагаа зогсох тохиолдол байдаг бөгөөд үүнийг телевизийн болон ухаалаг утасны цаг агаарын мэдээнээс урьдчилан тооцоолох боломжтой болсон.	-

2	Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу байрлуулж бэлэн байдлыг хангаж ажиллах	Уурхайн бүс нь говийн бүс нутагт хамаарах тул тэл хээрийн бүстэй харьцуулахад гал түймрын аюул харьцангуй багатай. Ажлын байр, амрах байр гэх мэт объектын гар түймрээс сэргийлэх үүднээс галын мэдрэгч, гал унтраах хэрэгсэлээр хангагдсан. Тайлант онд галын хор 20 ш, хүрз 10 ш, галын цохиур 2 ш гэх мэт хэрэгцээт зүйлсээр хангасан.	1,380.0
3	Газар хөдлөлт, чичирхийллийн улмаас үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	ХАБЭА-н төлөвлөгөө, дотооддоо мөрдөх гамшиг ослын үеийн төлөвлөгөөтэй. Ажилчдад аливаа осол эрсдлийн үед өөрийгөө хэрхэн хамгаалах, цугларах цэгийн ойлголтыг ХАБЭА-н сургалтын хүрээнд таниулга хийдэг.	Үйл ажиллагааны зардал
Үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр			
4	Үйлдвэрийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрийн үйл ажиллагаа доголдох, зогсох	- Ажилчдад өдөр тутмын зааварчилагаа өгдөг. - Оны эхэнд “ХЭМАББО” эрдэм шинжилгээ, сургалт судалгааны төвөөс нийт ажилчдын болон удирдах ажилтаны сургалт авсан.	3,000.0
		Ажилчдад зуны нормт хувцас, ажлын бээлий, маск гэх мэт нэг бүрийн хувцас хэрэглээр тухай бүр бүрэн хангаж ажиллаж байна.	21,012.0
		Түрээсийн тоног төхөөрөмжүүдийн машин техникийн үзлэгийг сар бүрийн 15-нд нэгдсэн журмаар зохион байгуулдаг бөгөөд нэг бүрийн хэрэгслийн бэлэн байдлыг байнга шалгаж, дутсан болон эвдэрсэн нөхцөлд нөхөж болон засвар хийлгэж байна.	Түрээсийн техникийн зардал
Эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ			
5	Хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх эрсдэл	- Тоос гаргахгүй боломжит бүх нөхцөлийн өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан байнга хийдэг /усалгаа, зам талбайг түрэх, хурд тохируулах, салхины эрчим ихтэй үед уурхайн үйл ажиллагааг зогсоодог/ - УБ хотын УЦУОШГ-ийн “Байгаль Орчин, Хэмжил Зүйн Төв Лаборатор”-т хавар болон намар 2-тоо дуу чимээ, хөрс, ус, агаарын шинжилгээг 2 удаа, усны шинжилгээг улирал бүшр буюу 4-н удаа хийлгэсэн. - Шимт хөрсны ургамалын ургалтанд байнгын хяналт тавьдаг бөгөөд 5, 6 сард ургамалын ургалтын үед усалгаа хийсэн. Мөн олон наст ургамал болох согооворын үр тарьж ургуулсан.	зардлыг орчны хяналт шинжилгээний ажилд оруулсан.
	Дүн		25,392.0



Зураг 43. Галын хорыг шинээр нэмж байршуулсанаас гадна хяналтын хуудастай болсон




Зураг 44. Ажилчдыг иж бүрэн нормын хувцасаар хангасан



Зураг 45. Ажилчин нарядыг ээлж эхлэх бүрт өгдөг



Зураг 46. Нийт ажилчид болон удирдах ажилтаны сургалт / 2024.02.01-нд/



Зураг 47. Орчны шинжилгээг 2024 оны 07, 10-р сард хийв. Усны шинжилгээг улирал бүр хийв.

2.6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 15. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Гүйцэтгэсэн ажил	Зардал мян.төг
1	Хөрс, ус, агаарын бохирдол үүсэх	Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгалт хийх зорилгын хүрээнд уурхайн ажилчдын тосгонд тэмдэгжүүлсэн, 3-н тусгаарлалт бүхий ахуйн 2 хогийн савыг 2020, 2022 онд ашиглалтанд өгч үр дүнтэй ашиглаж байна. Ахуйн хэрэглээний хатуу хог хаягдлыг нэгдсэн байдлаар Олон-Овоо багийн хогийн цэгт сар бүр тээвэрлэн төвлөрүүлж байлаа. Холбогдох гэрээг байгуулан төлбөрөө төлсөн.	Нийт: 4,986.1 2,586.1 2,400.0
		2021 онд грашын талбайг бүрэн цэментэн суурьтай болгосон бөгөөд техникийн засвар үйлчилгээг уг байранд хийлгэсэнээр хөрс бохирдуулахаас сэргийлдэг. Мөн 2023 онд техник засвар хийх гадна талбайг 6 мх16 м буюу 96 м² талбайг 20-30 см зузаантайгаар төмөр бетон цутгалт хийв. 2024 онд шинээр граш барьж, шалыг 20 см зузаантайгаар цементэлсэн.	Зардал нь хөрс хамгаалах ажилд тусгагдсан
		Ангилан ялгах хогийн саванд цугларсан 2 догч түүхий эд болох ундаа усны хуванцар савыг Улаанбаатар хотод тушаасан. Түлшний зардал гарав.	139.2
		Аюултай хог хаягдал болох гидро болон тосыг хог хаягддаг боловсруулагч “Клин ойл”ХХК-тай гэрээ байгуулж зориулалтын газарт хуримтлал үүсгэж байгаад тушаадаг. Тайлант оны 8-н сарын 31-нд 3400 литр шингэн хаягдал тушаасан.	278.4
		Хаягдал тос болон түлшний шүүр тунгаах 2 ш савыг хийж дээд болон доод хаягдал тос хадгалах цэгт байршуулан ашиглаж байна.	50.0
Физик нөлөөллийг бууруулах чиглэлээр			
2	Үйлдвэрийн тоног төхөөрөмж, машин механизмын хөдөлгүүрээс үүдэлтэй шуугиан ажиллагсдын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлнэ.	Ажилчдын амрах байрыг шинээр зохион байгуулж битүү дээвэртэй болгож, дуу чимээ тусгаарлалт, дулаан хангамж, ая тухтай нөхцөлийг бүрдүүлсэн. Орчны дуу шуугианы хэмжилтийг жилд 2 удаа хийлгэж байна. Дуу чимээ зөвшөөрөгдөх хэмжээнд байна. Бутлуурын ажилчдад хамгаалах чихэвчийг тогтмол ашиглуулдаг.	50.0
	Дүн		5,503.7



Зураг 48. Ахуйн хог хаягдлын цэг /2020 онд тохижуулсан бөгөөд үргэлжжүүлэн ашиглаж байна./



Зураг 49. Дахивар хаягдлыг төвлөрүүлэх цэг / Туслан гүйцэтгэгчийн кемп/



Зураг 50. Бүх нийтийн цэвэрлэгээ



Зураг 51. Ажилчдын байр өмнө нь



Зураг 52. Ажилчдын байр /2023 он /



Зураг 53. Ажилчдын байр /2024 он /



Зураг 54. Шинэ гал тогооны байр /2024 он /



Зураг 55. Хаягдал тос, дугуйг хүлээлгэн өгч байгаа нь /2024 оны 8-р сарын 31-нд/

БАТЛАВ:

“ФРИЕНДШИП РЕСУРСИС” ХХК-ийн
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.МӨНХТУЯА

Техникийн хаягдал тос, тосолгооны шингэний хаягдалыг
хүлээлгэн өгөх гэрээ

БАТЛАВ:

“КЛИН ОЙЛ” ХХК-ийн
“ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.МӨНХДОРЖ

2023 оны 06-р сарын 22-ны өдөр

ОРЛОГЫН ПАДААН №

(байгууллагын нэр)

2024 он 08 сар 31 өдөр

(бэлтгэн нийлүүлэгчийн нэр)

Дагалдах баримт №

№	Материалын үнэт зүйлийн нэр, зэрэг, дугаар	Код	Хэмж х нэгж	Нэг бүрийн үнэ	Хүлээн авсан	
					Тоо	Үнэ
	Ариутгал хөл халдас Тос маас		Т		2 тн 2000	

Тэмдэг

УЛААНБААТАР ХОТ
“КЛИН-ОЙЛ”
Хүлээн авсан

Б.Мөнх-Дорж
Мөнх-Дорж

ОРЛОГЫН ПАДААН №

(байгууллагын нэр)

2024 он 08 сар 31 өдөр

(бэлтгэн нийлүүлэгчийн нэр)

Дагалдах баримт №

№	Материалын үнэт зүйлийн нэр, зэрэг, дугаар	Код	Хэмж х нэгж	Нэг бүрийн үнэ	Хүлээн авсан	
					Тоо	Үнэ
	Ариутгал хөл халдас Тос маас		Т		1 тн 1200 тн	

УЛААНБААТАР ХОТ

Зураг 56. Байгуулсан гэрээ, тушаасан баримт



Зураг 57. Хаягдал тос болон түлшний шүүр тунгаах сав



Зураг 58. Ахуйн хог хаягдлыг сар бүр нэгдсэн хогийн цэгт зөөвөрлөн төвлөрүүлдэг

2.7 Удирлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт


Уурхайн удирдлагын зүгээс байгаль хамгаалах бодитой ажлаас гадна шаардлагатай бичиг баримтын бүрдэл, судлагаа, хяналтын ажлыг хуулийн хугацаанд тасралгүй явуулахад анхааран ажиллаж байна. Тайлант онд 2 жил тутам хийлгэх ёстой аудит, БОННУ-д тусгагдсан багийн иргэдийн хүнсний эрүүл ахуйн нэг хэсэг болсон малын эрүүл мэндийг хамгаалах ажлын хүрээнд “мал угаалгын ванн” барих ажлын өөрийн хөрөнгө санаачлагаар хийж хэрэгжүүлээ.

Хүснэгт 16. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№	Арга хэмжээ	Гүйцэтгэсэн ажил	Зардал мян.төг
1	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн ажлууд	Бүх ажилчдын болон удирдах ажилтаны сургалтыг 2024 оны 2-р сард мэргэжлийн байгууллага болох “ХЭМАББО” эрдэм шинжилгээ сургалт судалгааны төвөөр хийлгэсэн.	3,000.0 /осол эрсдэлийн хэсэгт орсон/
		Байгаль орчин хамгаалах чиглэлээрх яриа таниулгыг /ихэвчлэн хог хаягдал ангилах, аюултай хог хаягдлын тухай/ сар бүрийн 15-ний бүх ажилчдын хурлаар хийдэг. Сумын байгаль орчны ажилтантай холбоотой ажиллаж тухайн жил төлөвлөгдсөн сумтай холбоотой ажлыг гүйцэтгэлээ.	0.0
		Байгаль орчны аудитыг “Сайн тусгал”ХХК-иар 2023 онд хийлгэсэн.	11,840.0 /өмнөх жил /
		Газрын төлөв байдал чанарын хянан баталгааг “Ворлд гоби”ХХК-ээр гэрээгээр 2022 онд гүйцэтгүүлсэн.	8,200.0 /өмнөх жил /
		Багийн иргэдийн 2-н хүүхдүүдийн сургалтийн төлбөрт 11.0 сая.төг, сум болон багийн иргэдэд өвс тэжээл 1200 боодол буюу нийт 15 сая.төг, өвөлжилт хүндэрсэнтэй холбоотойгоор 2024 оны хавар 03-р сард 500 боодол өвсийг 13.0 сая.төг, багийн 40-н айлд тус бүр 2 тн нүүрс буюу 12.0 сая.төг, сумын иргэдэд 100 тн нүүрс буюу 15.0 сая.төгрөг гэх мэт зардлуудыг одоогийн байдлаар шийдвэрлэж ажлаад байна. Эдгээрт 66.00 сая.төгрөг зарцуулав. БОННУ-д тусгагдсаны дагуу багийн малчдад усны хүртээмжийг ойртуулах үүднээс 120 м гүнтэй гүний худаг 1 ш-ийг эрх бүхий байгууллагаар гаргуулав. Тохижилтын ажил хийж дуусаагүй. Үүнд 18.0 сая.төгрөг зарцуулав. Мөн 2023 онд орон нутагт хийсэн мал угаалгын ваннд мал угааж эрүүлжүүлэх ажил тайлант оны 8-р сард хийгдэхэд уурхайн зүгээс хэрэгцээт усаар хангаж ажиллав. Үүнд 8-н өрхийн 2597 бог мал хамаарагдав.	84,000.0
	Дүн		102,000.0



Зураг 59. Уурхай дээр 1200 боодол өвсийг иргэдэд тараахаар бэлтгээд байна.



Зураг 60. Мал угаах ажил хийгдэв

Хүмүүнлэгийн ухааны их сургууль

Борлуулагч
ТТД: 9086366
Нэр: Хүмүүнлэгийн ухааны их сургууль
Хаяг:
Банкны нэр:
Банкны дансны дугаар:

Худалдан авагч
ТТД: 5877288
Нэр: Фриендшип ресурсис
Хаяг: Монгол, Дорноговь, Сайншанд, 2-р баг, 51

ДДТД: 000009086366001241022000001158887
Огноо: 2024-10-22 14:09:03

№	Бараа	т/ш	үнэ	Дүн
1	Боловсрол, мэргэжил олгох үйлчилгээ	1	6,288,000.00	6,288,000.00
Нийт үнэ:			6,288,000.00	
НӨАТ:			0.00	
Бүгд үнэ:			6,288,000.00	



Зураг 61. Багийн иргэдийн оюутан залуучуудыг дэмжих ажлын хүрээнд 2 хүүхдийн сургалтын төлбөр



Зураг 62. Сумын хандивын нүүрс



Зураг 63. Багийн малчдад зориулж гаргасан худаг.

3 2023 ОНЫ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАН

Уурхай орчны няналт шинжилгээний ажлын хүрээнд Улаанбаатар хотын УЦУОШГ-ийн дэргэдэх “Байгаль Орчин, Хэмжил Зүйн Төв Лаборатор”-т 2023 оны 7 болон 10-р сард хөрс, ус, агаар болон орчны дуу чимээнд шинжилгээний ажил хийлгэсэн.

2-р сар болон 8-р сард цэвэр, бохир усны шинжилгээг тус лаборатор болон “Усны газар”-ын дэргэдэх лабораторт хийлгэсэн.

Ингэхдээ өмнөх жилүүдэд хийсэн цэгүүдэд давтан хийсэн нь харьцуулах, суурь мэдээлэл үүсгэх боломжыг бүрдүүлж эхлэж байна.

2023 оны 2 удаагын бүрэн шинжилгээ болон 2 удаагын усны шинжилгээний ажлын зардалд 1,305.0 мян.төг зарцуулсан байна.

10-р сарын сүүлээр өгсөн шинжилгээний үр дүн хараахан гараагүй байгаа тул тайланд мэдээлэл болон үр дүнг оруулах боломжгүй байлаа.

3.1.1 Агаарын бохирдол

Хүснэгт 17. Агаарын чанарын хэмжилтийн дүн (2021 он 7 болон 9-р сар)

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м³	Азотын давхар исэл мг/м³	Нийт тоос /TSP/мг/м³	Дуу чимээ /ДБА/
1	Нүүрс бутлах ачих талбай	VII/05	13:40	0.019	0.032	0.246	62
		IX/14	19.20	0.025	0.028	0.057	56
2	Ажилчдын кемп, автозогсоол орчим	VII/05	14:25	0.015	0.024	0.087	42
		IX/14	18:50	0.020	0.018	0.068	54
3	Уурхай	VII/05	13:00	0.017	0.035	0.186	58
		IX/14	19.40	0.034	0.030	0.065	54
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016				0.450	0.200	0.500	60

Хүснэгт 18. Агаарын чанарын хэмжилтийн дүн (2022 он 9-р сар)

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м^3	Азотын давхар исэл мг/м^3	Нийт тоос /TSP/ мг/м^3	Дуу чимээ /ДБА/
1	Нүүрс бутлах ачих талбай	IX/11	10:05	0.019	0.025	0.091	70
2	Ажилчдын кемп, автозогсоол орчим	IX/11	09:00	0.015	0.023	0.079	44
3	Уурхай -Салхин дээр	IX/11	09:35	0.017	0.020	0.075	55
4	Уурхай – Салхин доор	IX/11	10:30	0.014	0.022	0.077	48
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016				0.450	0.200	0.500	60

Хүснэгт 19. Агаарын чанарын хэмжилтийн дүн (2023 он 5-р сар)


№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м ³	Азотын давхар исэл мг/м ³	Нийт тоос /TSP/мг/м ³	Дуу чимээ /ДБА/
1	Нүүрс бутлах ачих талбай	V/06	13:35	0.015	0.022	0.235	50
2	Ажилчдын кемп, автозогсоол орчим	V/06	11:50	0.011	0.019	0.074	54
3	Уурхай -Салхин дээр	V/06	12:25	0.010	0.015	0.035	30
4	Уурхай – Салхин доор	V/06	12:55	0.008	0.017	0.174	50
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016				0.450	0.200	0.500	60

Хүснэгт 20. Агаарын чанарын хэмжилтийн дүн (2024 он 7-р сар)


№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м ³	Азотын давхар исэл мг/м ³	Нийт тоос /TSP/мг/м ³	Дуу чимээ /ДБА/
1	Ажилчдын кемп	VII/02	14:20	0.012	0.027	0.200	48
2	Уурхай – Салхин доор	VII/02	13:40	0.013	0.043	0.560	50
3	Уурхай -Салхин дээр	VII/02	11:00	0.012	0.030	0.136	54
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016				0.450	0.200	0.500	60

Тайлбар:

Хүхэрлэг хийн (SO₂) агууламж зөвшөөрөгдөх хэмжээнээс даваагүй, азотын давхар ислийн (NO₂) агууламж агаарын чанарт сөрөг нөлөөлөл үзүүлэх хэмжээний байхгүй ба тоосонцорын хэмжээ зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс даваагүй. Мөн нүүрс ачих, бутлах хэсэгт их, дуу чимээний хэмжээ ихтэй байдаг тул бутлуурын ажилчдад дуу чимээний хамгаалалтыг үргэлжлүүлэн хийх хэрэгтэй. Нийт тоос өсч гарсан нь тухайн өдөр салхи ихтэй байсантай шууд холбоотой.



Зураг 64. Агаарын чанарын дээжлэлтийн үр дүн-Хүхэрлэг хийн жил бүрийн үзүүлэлтээр график байгуулалт хийхэд 2023 он хүртэл буурч байгаад 2024 онд өсөх хандлагатай гарсан байна..



Зураг 65. Агаарын чанарын дээжлэлтийн үр дүн-Нийт тоосонцорын жил бүрийн үзүүлэлтээр график байгуулалт хийхэд 2023 он хүртэл буурч байгаад 2024 онд огцом өсөлттэй гарсан.



Зураг 66. Агаарын чанарын дээжлэлт хийж буй байдал /2024 оны 7-р сар/

3.1.2 Хөрсний хими, физик шинж чанар, хүнд металлын шинжилгээ

Хөрсний морфологи тогтоцын хувьд хүрэн өнгөтэй, нягт, жижиг чулуутай, ургамлын үндэстэй, ургаман бүрхэвч 70%, хуурай, бүтэц алдагдсан, үе давхарга хоорондын шилжилт тод байна.

Хөрс нь сул хүчиллэгээс сул шүлтлэг урвалын орчинтой, карбонатгүй, ялзмагийн агууламж бага зэрэг, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфорын хангамж бага зэрэг, хөдөлгөөнт калийн хангамжаар бага, механик бүрэлдэхүүн элсэнцэр. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин бага байна.

Хөрсний химийн шинжилгээ: 2020, 2022, 2023, 2024 онуудад онд хийсэн хөрсний лабораторийн задлан шинжилгээний дүнгээс үзэхэд ялзмагийн хэмжээ 0.6%-1.5% болж нэмэгдсэн, хөрсний pH тогтвортой буюу 7 орчим байгаа зэрэг нь хөрсний хими шинж чанарын түвшин болон ургамал ургах орчин сайн байгааг илтгэж байна. Харин шимт тэжээлийн элемент болох фосфорын хэмжээ буурсан хандлагатай байна. Мөн 2 байгууллагын шинжилгээний хариу эрс өөр байгаа нь учрыг одоогоор тогтоогоогүй.

Хүснэгт 21. Хөрсний химийн үндсэн шинж /2020 оны шинжилгээ/

Дээжийн дугаар	Гүн /см/	pH /1:5/	Чийг %	Ялзмаг %	NO ₃ мг/кг	Хөдөлгөөнт, мг/100г	
						P ₂ O ₅	SO ₄
1	0	7.9	0.96	0.6	3.2	41.0	19.6

Хүснэгт 22. Хөрсний химийн үндсэн шинж /2022 оны 09-р сар /

Дээжийн байршил	Гүн /см/	pH /1:5/	Чийг %	Ялзмаг %	Аммоны азот (NH ₄ -N) мг/кг	NO ₃ мг/кг	Хөдөлгөөнт, мг/100г	
							P ₂ O ₅	SO ₄
Отвол /модны орчим/	0	6.53	2.56	0.86	193.0	185.2	16.0	149.5

Хүснэгт 23. Хөрсний химийн үндсэн шинж, дээжийн гүн 0-30 см /2023 оны 05-р сар /

Дээжийн байршил	pH /1:5/	Чийг %	Ялзмаг %	Аммоны азот (NH ₄ -N) мг/кг	NO ₃ мг/кг	Хөдөлгөөнт, мг/100г	
						P ₂ O ₅	SO ₄
Отвал/модны орчим/	7.1	1.01	0.97	19.1	4.2	17.4	121.2
Шимт хөрсний овоолго	7.2	1.03	0.15	28.4	4.5	11.6	12.6

Хүснэгт 24. Хөрсний химийн үндсэн шинж, дээжийн гүн 0-30 см /2023 оны 06-р сар “Байгаль орчин судалгаа шинжилгээний газар /

№	Дээжийн байршил	pH /1:5/	Давс, %	Ялзмаг %	Солилцох сууриуд, мг-экв/100г		Шим тэжээлийн элементүүд, мг/100г	
					Ca ⁺²	Mg ⁺²	P ₂ O ₅	K ₂ O
1	Засварын төв	8.44	0.11	1.20	12	1	1.2	24
2	Шимт хөрсний овоолго	7.18	0.01	1.27	10	8	1.5	22
3	Нөхөн сэргээлтийн талбай	7.58	0.45	1.93	6	11	0.2	35
4	Замын хажуу	8.13	0.12	1.5	12	8	1.6	29
5	Кемп	7.11	0.02	1.42	12	9	1.7	26
6	Ил уурхай	7.31	0.39	2.01	8	12	0.9	37

7	Хяналт дээж	7.06	0.01	1.76	13	10	1.6	70
---	-------------	------	------	------	----	----	-----	----

Хүснэгт 25. Хөрсний химийн үндсэн шинж, дээжийн гүн 0-30 см /2024 оны 07-р сар /

Дээжийн байршил	рН /1:5/	Чийг %	Ялзмаг %	Аммоны азот (NH ₄ -N) мг/кг	NO ₃ мг/кг	Хөдөлгөөнт, мг/100г	
						P ₂ O ₅	SO ₄
Отвал/модны орчим/	8.0	1.18	1.9	29.5	2.2	0.9	28.9
Кемп	8.4	1.15	2.8	10.4	1.8	0.6	13.0



Зураг 67. рН-ийн орчин тогтвортой, ялзмагын хэмжээ нэмэгдэх хандлагатай байна.

Хөрсний механик бохирдол:

2021 онд хөрсний механик бохирдол буюу хүнд металлын агууламжийг төслийн талбайд 4-н цэг сонгон авч шинжлүүлэхэд ЗДХ-ээс хэтэрсэн буюу бохирдолтой хөрс илрээгүй байна.

Хүснэгт 26. Хөрсний хүнд металлын сорьц (2021 он 7 болон 9-р сар)

№	Сорьц авсан цэг	Он.сар	Cd	Pd	Hg	Cr	Zn	Cu	Co	Sr
1	Бутлуурын орчим	IX/14	Ил-гүй	14.6	Ил-гүй	Ил-гүй	75.2	26.3	7.5	213.1
2	Кемп орчим	VII/07	Ил-гүй	24.5	Ил-гүй	Ил-гүй	119.6	29.3	15.7	398.1
3		IX/14	1.5	17.9	Ил-гүй	Ил-гүй	107.4	24.02	37.5	216.7
4	Отвал	VII/07	Ил-гүй	19.4	Ил-гүй	Ил-гүй	85.4	26.3	11.9	378.7
5	Бензин түгээгүүр	VII/07	Ил-гүй	20.7	Ил-гүй	Ил-гүй	119.6	29.3	15.7	398.1
MNS 5850:2019 /ЗДХ/			3	100	2	150	300	100	50	800

Нэршил: Cd- Кадьми, Pd- Хар тугалга, Hg- Мөнгөн ус, Cr- Хром, Zn- Цайр, Cu- Зэс, Co- Кобальт, Sr- Стронци

2022 онд хөрсний механик бохирдол буюу хүнд металлын агууламжийг төслийн талбайд 3 цэг сонгон авч шинжлүүлэхэд ЗДХ-ээс хэтэрсэн буюу бохирдолтой хөрс илрээгүй байна.

Хүснэгт 27. Хөрсний хүнд металлын сорьц (2022 он 9-р сар)

№	Сорьц авсан цэг	Он.сар	Cd	Pd	Hg	Cr	Zn	Cu	Co	Sr
1	Бутлуурын орчим	IX/11	2.1	16.1	<0.0005	<0.0005	39.7	29.1. 3	8.0	243.9
2	Уурхайн салхин доор	IX/11	0.9	12.8	<0.0005	<0.0005	41.2	28.7	11.0	231.1
3	Отвал	IX/11	<0.0005	16.6	<0.0005	<0.0005	60.0	29.1	26.7	195.1
MNS 5850:2019 /ЗДХ/			3	100	2	150	300	100	50	800

2023 онд хөрсний механик бохирдол буюу хүнд металлын агууламжийг төслийн талбайгаас 5-р сард 1 цэг сонгон авч шинжлүүлэхэд ЗДХ-ээс хэтэрсэн буюу бохирдолтой хөрс илрээгүй байна.

Хүснэгт 28. Хөрсний хүнд металлын сорьц (2023 он 5-р сар)

№	Сорьц авсан цэг	Он.сар	Cd	Pd	Hg	Cr	Zn	Cu	Sr
1	Технологийн зам дагуу	V/08	0.005	11.9	<0.005	<0.005	64.3	30.7	241.9
MNS 5850:2019 /ЗДХ/			3	100	2	150	300	100	800

Нэршил: Cd- Кадми, Pd- Хар тугалга, Hg- Мөнгөн ус, Cr- Хром, Zn- Цайр, Cu- Зэс, Co- Кобальт, Sr- Стронци

6-р сард “Байгаль орчны судалгаа шинжилгээний төв” ирэхдээ нийт 8-н цэгээс дээжлэлт хийж хүнд металлын шинжилгээг 33-н элементэд хийсэн. Өмнөх шинжилгээний үр дүнтэй харьцуулах үүднээс 7-н элементийн үр дүнг энд орууллаа. Үр дүн зөвшөөрөгдөх хэмжээнд.

№	Сорьц авсан цэг	Он.сар	PPM 1 10,000 Cd	% 0.01 15 Mg	PPM 2 10,000 Mn	PPM 1 10,000 Cr	PPM 1 10,000 Zn	PPM 1 10,000 Cu	PPM 0.5 10,000 Sr
1	Дотоод овоолго	VI/18	<1	0.35	296	38	108	34.0	130
2	Засварын төв	VI/18	<1	0.37	478	18	80	22.1	190
3	Шимт хөрсний овоолго	VI/18	<1	0.16	277	15	48	16.4	143
4	Нөхөн сэргээлтийн талбай	VI/18	<1	0.41	314	22	66	10.2	223
5	Замын хажуу	VI/18	<1	0.11	221	11	42	8.8	113
6	Кемп	VI/18	<1	0.27	391	11	78	47.3	271
7	Уурхай	VI/18	<1	0.34	222	28	87	30.7	171
8	Хяналт дээж	VI/18	<1	0.19	348	18	63	18.3	148
MNS 5850:2019 /ЗДХ/			3			150	300	100	800

2024 онд 7 болон 10-р сард хөрсний хүнд металлын шинжилгээг хийлгэсэн бөгөөд 10-р сарын хариу хараахан гараагүй байна. 7-р сарын мэдээлэлд үндэслэн үр дүнг нэгтгэв.

Төлөөлөх дээжийг уурхай дотроос авсан нь механикмын ажлын бүс болох бөгөөд энэ нь хүнд металлын хэмжээ өмнөх жилүүдээс их гарах үндэс болсон гэж үзэж болхоор байна. 10-р сарын сүүлээр авсан хөрсний шинжилгээний үр дүнг өмнөх жилүүдтэй харьцуулах нь илүү бодитой үр дүнг илэрхийлэх боломжтой гэж үзэж байна.

Хүснэгт 29. Хөрсний хүнд металлын сорьц (2024 он 7-р сар)

№	Сорьц авсан цэг	Он.сар	Cd	Pd	Hg	Cr	Zn	Cu	Sr
1	Уурхай	VII/02	2.4	19	<0.005	<0.005	96.0	30.0	383.0
MNS 5850:2019 /ЗДХ/			3	100	2	150	300	100	800



Зураг 68. Хөрсний дээжлэлт хийж буй байдал /2024 оны 10-р сар/

3.1.3 Усны шинжилгээ

Уурхай жил бүр унд, шүүрэл, бохир усандаа шинжилгээний ажлуудыг тогтмол хийдэг. Энэ жишгийн дагуу 2024 онд доор шинжилгээнүүдийг өгөв. Үүнд:

- 1. 2-р сард: Ундны ус
- 2. 3-р сард: Бохир ус
- 3. 7-р сард: Ундны ус, кемпийн худаг, малчны худаг
- 4. 8-р сард: Ундны ус
- 5. 10-р сард: Ундны ус, бохир ус, шүүрлийн ус


Шинжилгээний үр дүнгүүдээс үзэхэд зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй байна.

Хүснэгт 30. Ундны усны шинжилгээний үр дүн

Сорьцын нэр	pH	EC uS/cm	SO ₄ мг/л	Cl мг/л	Ca мг/л	Mg мг/л	Na+K мг/л	HCO ₃	Эрд	Хат мг/- экв/л
Ундны худаг /2022/	7.83	416	48.3	50.0	17.4	17.9	71.7	170	375	2.34
Ундны худаг /2023/	8.76	983	148	123	27.0	29.1	183	274	784	3.74
Ундны худаг /2024-2/	7.8	1292	125	106	32.9	28.7	156	284	733	4.0
Ундны худаг /2024-7/	7.9	1044	128	96.1	43.3	43.3	148	293	822	5.72
Ундны худаг /2024-8/	7.59	1240	172	85.1	50.1	66.9	174	512		8.0
MNS 0900:2018	6.5- 8.5	1000	500	350	100	30	-	-	-	7.0

Хүснэгт 31. Ундны усны шинжилгээний үр дүн

Сорьцын нэр	Ж/б мг/л	ПИЧ мг/л	NH ₄ мгN/л	NO ₂ мгN/л	NO ₃ мгN/л	PO ₃ мгP/л	Fe мг/л	F мг/л
Ундны худаг /2022/	0.6	1.2	0.02	0.005	2.60	0.001	0.02	0.70
Ундны худаг /2023/	9.4	1.6	0.67	0.233	3.28	0.001	-	0.87
Ундны худаг /2024-2/	0.8	0.5	0.01	0.023	64.28	0.010	0.08	1.32
Ундны худаг /2024-7/	2.6	1.6	0.09	0.013	18.9	0.048	0.01	3.46
Ундны худаг /2024-8/			0.34	0.0	0.34		0.09	
MNS 0900:2018	-	-	1.5	1.0	50	3.5	0.3	0.7-1.5



Зураг 69. Хатуулагийн хэмжээ нэмэгдэх хандлагатай, pH орчин 2023 он хүртэл нэмэгдэх хандлагатай байсанаас 2024 онд буурсан байна.

Уурхай 2024 онд уурхайн бүс дотор болон малчны худаг тус бүр 1 ширхэгийг гаргасан. Худаг өрөмдсөний дараа худгийн уснаас дээж авч шинжилгээнд хамруулсан. Үр дүнг доор үзүүлэв. Үр дүнгээс үзэхэд цаашдаа малчдад зориулсан худгаас ундандаа хэрэглэх, кемпэд өрөмсөн худгаас ахуйдаас хэрэглэх боломжтой гэж үзэж байна.

Хүснэгт 32. Шинээр өрөмдсөн худгуудын усны шинжилгээний үр дүн

Сорьцын нэр	pH	EC uS/cm	SO ₄ мг/л	Cl мг/л	Ca мг/л	Mg мг/л	Na+K мг/л	HCO ₃	Эрд	Хат мг/- экв/л
Кемпийн худаг	7.27	2060	305	80.8	95.8	99.2	139	601	1321	12.94
Малчны худаг	7.52	1779	241	55.7	49.9	46.0	180	421	994	6.27
MNS 0900:2018	6.5-8.5	1000	500	350	100	30	-	-	-	7.0

Хүснэгт 33. Шинээр өрөмдсөн хугдгуудын усны шинжилгээний үр дүн

Сорьцын нэр	Ж/б мг/л	ПИЧ мг/л	NH ₄ мгN/л	NO ₂ мгN/л	NO ₃ мгN/л	PO ₃ мгP/л	Fe мг/л	F мг/л
Кемпийн худаг	32.8	1.8	0.08	0.003	0.97	0.012	0.03	0.92
Малчны худаг	41.2	1.3	0.24	0.003	0.35	0.010	0.01	1.24
MNS 0900:2018	-	-	1.5	1.0	50	3.5	0.3	0.7-1.5

Бохир усны шинжилгээг гал тогооны усанд хийлгэхэд жинлэгдэгч бодис, хими болон биохимийн хэрэгцээт хүчилтөгрөгч зөвшөөрөгдөх хэмжээнээс 2-аас 17 дахин их байгаа нь усыг соруулж зайлуулаагүй, боловсруулалт хийгддэггүйтэй шууд холбоотой.

Хүснэгт 34. Бохир усны шинжилгээний үр дүн

Сорьцын нэр	pH	Ж/б мг/л	XXX мг/л	BXX ₅ мг/л	NH ₄ - N мгN/л	NO ₂ - N мг/л	NO ₃ - N мг/л	N _{нийт} мг/л	Рэрдэс мг/л
Ахуйн бохир- гал тогоо /2024 /	7.18	64.0	805	348	2.26	0.331	1.9	3.68	0.303
MNS 0900:2018	6-9	30	50	20	-	-	-	15	1.5

2023 оны 5-р сард удаа уурхайн шүүрлийн усанд химийн ерөнхий шинжилгээ хийлгэсэн. Сульфатын хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс их гарсан бөгөөд шүүрлийн усыг зөвхөн зам талбай, ногоон байгууламжын усалгаанд ашиглаж байна.

Хүснэгт 35. Шүүрлийн усны шинжилгээний үр дүн

Сорьцын нэр	pH	EC uS/cm	SO ₄ мг/л	Cl мг/л	Ca мг/л	Mg мг/л	Na+K мг/л	HCO ₃	Эрд	Хат мг/- экв/л
Уурхайн шүүрлийн ус /2023.05.25/	8.03	4.19	934	177	192	216	142	552	784	27
Уурхайн шүүрлийн ус /2024.10/	10-р сард өгсөн шинжилгээний хариу гараагүй байна.									
MNS 0900:2018	6.5- 8.5	-	100	350	300	-	-	-	-	-

4. 2024 ОНЫ БОМТ-НИЙ ДАГУУ ХИЙГДСЭН АЖЛЫН НИЙТ ЗАРДЛЫН НЭГТГЭЛ

Уурхай 2024 онд байгаль орчин хамгаалах төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус ажлын хүрээнд нийтдээ 260.7 сая.төгрөгийн зардал гаргасан байна.

Хүснэгт 36. 2024 оны БОМТ-ний дагуу хийгдсэн ажлын биелэлтийн зардлын нэгдсэн тооцоо

№	Бүрэлдэхүүн хэсгүүд	Зардал мян.төг
1	Агаар мандалд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн зардал	44,452.30
2	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн зардал	504.00
3	Хөрсөн бүрхэвчид учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн зардал	12,981.77
4	Нөхөн сэргээлтийн арга хэмжээний биелэлтийн зардал	14,914.90
5	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний биелэлтийн зардал	3,000.00
6	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн зардал	50,664.00
6	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлтийн зардал	25,392.00
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн зардал	5,503.73
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийн зардал	102,000.00
11	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийн зардал	1,305.00
	Нийт дүн	260,717.70